



ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 03 сарын 02 өдөр

Дугаар А/12

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5, 20.2.8 дахь заалт, Донорын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн “Цусны салбар төвүүдийн жилийн үйл ажиллагааг дүгнэх журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цусны салбар төвүүдийн 2021 оны үйл ажиллагааг үнэлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Захиргаа маркетингийн албаны дарга /Ч.Батболд/
Нарийн бичиг: Цусны чанар аюулгүй албаны дарга /А.Амарзаяа/
Гишүүд: Үйлдвэрийн тасгийн эрхлэгч /Н.Халиун/
Нэгдсэн лабораторийн тасгийн эрхлэгч /М.Цэрэндэжид/

Донор зохион байгуулалтын тасгийн эрхлэгч /Ч.Тунгалаг/

2. Цусны салбар төвийн үйл ажиллагааг үнэлэх ажлын удирдамжийг хавсралтаар баталсугай.


3. Ажлын хэсгийг удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллаж, шалгаруулалтын дүнг 2022 оны 3 дугаар сарын 11-ны дотор Ерөнхий захиралд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Ч.Батболд/-д даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Н.ЭРДЭНЭБАЯР

1118266548 9128905

080087



ЦУСНЫ САЛБАР ТӨВҮҮДИЙН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ
ҮНЭЛЭХ АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг. Зорилго:

Энэхүү удирдамжийн зорилго нь Цусны салбар төвүүдийн 2021 оны үйл ажиллагааг дүгнэн, байр эзлүүлж, шагнаж урамшуулан, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэхэд оршино.

Хоёр. Зорилт:

- Жилийн ажлын гүйцэтгэлийг үнэлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;
- Цусны салбар төвүүдийн “Сайн туршлага”-ыг түгээн дэлгэрүүлэх;
- Үнэлгээний дүнгээр “Дутагдалтай”, “Хангалтгүй” дүгнэгдсэн Цусны салбар төвүүдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох.

Гурав. Хамрах хүрээ:

Аймаг, орон нутгийн Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн төвийн дэргэдэх 26 Цусны салбар төв

Дөрөв. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- “Цусны салбар төвүүдийн жилийн үйл ажиллагааг дүгнэх журам”-ыг баримтлан Цусны салбар төвүүдийн 2021 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тайланг үнэлнэ.
- Цусны салбар төвүүдийн тайланг томилогдсон баг үнэлж, журмын дагуу үнэлсний дагуу “Тэргүүн” байр-1, “Дэд” байр-1, Гуравдугаар байр-1 тус тус шалгаруулна.

Тав. Хугацаа:

2022 оны 3 дугаар сарын 9-ны өдрийн 13:00 цагт, Хурлын өрөөнд

Зургаа. Хариуцах эзэн:

Захиргаа маркетингийн алба, Цусны чанар, аюулгүй байдлын алба